



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/06

Даланзадгад

Баяр ёслол, амралтын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах журам, хуваарийг батлах тухай

Засгийн газрын 2019 оны 01 сарын 16-ны өдрийн 31 дүгээр тогтоол “Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой авах зарим арга хэмжээний тухай”, эрүүл мэндийн Сайдын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/438 дугаар тушаал “Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж батлах тухай”, аймгийн Засаг даргын 2019 оны 01 сарын 18-ны өдрийн А/60 дугаар захирамж “Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай”, аймгийн Засаг даргын 2019 оны 01 сарын 22-ны өдрийн А/74 дүгээр захирамж “Олон нийтийн арга хэмжээг түр хугацаагаар хориглох тухай” тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг эрсдэлгүй чанартай хүргэх журам”-ыг нэгдүгээр, “Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах цагийн хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган, шаардлагатай тохиолдолд шуурхай зохион байгуулалтыг хийж, хүлээгдэл, чирэгдэл, хожимдолгүй ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.


3. Эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд хяналт тавьж, дүгнэлт гарган, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс /М.Цэндсүрэн/, Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Ж.Отгонбайгал/ нарт тус тусдаалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ


Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 02 сарын 01 өдрийн
А/06 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

САР ШИНИЙН БАЯР, АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРСДЭЛГҮЙ ЧАНАРТАЙ ХҮРГЭХ ЖУРАМ

БЭЛЭН БАЙДАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1. Сар шинийн баяр, амралтын үеэр эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх зорилгоор эмнэлэг бүр 2019 оны 03 сарын 16-ны өдрийг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах
2. Эмнэлгүүд иргэдэд томуу томуу төст өвчний чиглэлээр зөвлөгөө өгөх утас болон эмч мэргэжилтнүүд хоорондын хариуцлагатай утас ажиллуулах
3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажил, амралтын хуваарьт шаардлагатай зохицуулалт хийх, хариуцлагатай жижүүрийн хуваарь гаргаж, байгууллагын дарга батлах
4. Жижүүрт эх, хүүхдийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадвартай эмч томилох, ялангуяа жирэмсэн эмэгтэй, нярай хүүхдийн үзлэг оношилгоонд онцгой анхаарах, байгууллагын дарга хүлээн авахаар ирсэн үйлчлүүлэгч, түргэн тусламжийн дуудлага бүрийн мэдээллийг өдөрт нь авч, давхар хяналт тавьж ажиллах
5. Амралтын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах эм, ороох боох материал, өвчтөний хоол хүнсийг хүрэлцэх хэмжээгээр нөөцлөх, гал гарах, ус алдах эрсдэлээс сэргийлэх, цахилгааны аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, ажилчдын сонор сэрэмжийг дээшлүүлэх
6. Түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах, яаралтай тусламжийн эм эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, тослох материалын нөөцийг бүрдүүлэх, нэмэлтээр ажиллах хүн хүч авто машины бэлэн байдлыг хангах
7. Хэвтэн эмчлүүлэх ор бүхий эмнэлгүүд орны нөөцийг бэлэн байлгах, эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх
8. Болзошгүй гамшиг, халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдварын үеийн бэлэн байдлыг хангаж мэдээ мэдээллийг зохих журмын дагуу шуурхай мэдээлж ажиллах

ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Хяналтад байгаа нийт жирэмсэн бүрийг өрх, сум, багийн эмч нар хуваан авч, утсаар тогтмол хяналт тавих, зөвлөгөө зөвлөмж өгөх
2. Эрсдэлт бүлгийн жирэмсэн эмэгтэйчүүдийн үзлэгийг ажлын өдрүүдэд зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд 2-р шатлалд шилжүүлэх, эхийн амрах байранд байрлуулах зэрэг арга хэмжээг авах
3. Харьяаллын бус жирэмсэн эмэгтэйчүүдийн илрүүлэн хяналтад авах, иргэний үнэмлэхийн харьяаллаар өрх, сумын эмнэлэгт нь мэдээлэх, амралтын өдрүүдэд байх газрыг нь лавлан, тусламж үйлчилгээ авах талаар зөвлөгөө өгөх
4. Иргэдэд харьяаллын бус жирэмсэн эмэгтэйг аль ойр өрх, сумын эмнэлэгт заавал мэдээлж, бүртгүүлэх хэрэгтэй гэсэн мэдээлэл сурталчилгаа хийх
5. Жирэмсэн эмэгтэйн гэр бүлийн хэн нэгэн томуугаар өвчилсөн, эмчлүүлсэн бол урьдчилан сэргийлэх тунгаар Старфлу /тамифлу/ 75мг эмийг, өдөрт 1 удаа, 10 хоног уухыг зөвлөх /Старфлу эмийг жирэмсний аль ч хугацаанд хэрэглэж болно/


6. Жирэмсэн болон төрөөд 2 долоо хоног болоогүй эмэгтэйчүүдэд томуугийн эмнэлзүйн шинж тэмдэг илэрвэл эмчийн хяналдан дор Старфлу /тамифлу/ 75мг эмийг, өдөрт 2 удаа, 5 хоног уулгаж, шинж тэмдгийн эсрэг эмчилгээг яаралтай хийх
7. Жирэмсэн үеийн халууралтын үед халууныг яаралтай буулгах, Tylenol, түүнтэй ижил үйлчилгээтэй эм, Acetaminophen /парацетамол/-ыг хэрэглэхэд тохиромжтой
8. Эх барихуйн яаралтай дуудлагад хугацаа алдахгүй тусламж үйлчилгээ үзүүлэх үүднээс амралтын өдрүүдэд дуудагдах багийн хуваарь, эм тариа, машины бэлэн байдлыг хангасан төлөвлөгөө гарган, байгууллагын дарга баталсан байх

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Эмзэг, зорилтот бүлгийн хүүхдүүдийг өрх, сум, багийн эмч нар хуваан авч, эцэг эх, асран хамгаалагчтай утсаар холбогдон, тогтмол хяналт тавих, зөвлөгөө зөвлөмж өгөх
2. Бага насны хүүхдийн гэрийн эргэлтийг сайжруулах, чанаржуулах
3. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны 11 сарын 20-ны өдрийн "Томуу томуу төст өвчний тархалтын үед баримтлах оношилгоо эмчилгээний удирдамж"-ийг дагаж мөрдөх

Эрүүл мэндийн газрын 2019 оны 01 сарын 21-ний өдрийн "Хүүхдийн өвчний эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж, эмчилгээний зөвлөмж"-ийг дагаж мөрдөх /хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний дэлгэрэнгүй зөвлөмж гарсан/

Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 02 сарын 01 өдрийн А/06
тушаалын хоёрдугаар хавсралт



САР ШИНИЙН БАЯР, АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

№	Эрүүл мэндийн байгууллагууд	Ажлын өдрүүдэд	Амралтын өдрүүдэд
1.	Сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүд	09-18 цаг 02 сарын 04-ны өдөр 10-14 цаг	24 цагаар жижүүр эмч, сувилагч, шаардлагатай тохиолдолд эмч, мэргэжилтний баг, жолооч, үйлчлэгч
2.	Өрхийн эрүүл мэндийн төвүүд	09-18 цаг 02 сарын 04-ны өдөр 10-14 цаг	10-14 цагаар жижүүр эмч, сувилагч, шаардлагатай тохиолдолд жолооч /2 сарын 05-нд амарна/

ЭМИЙН САНГУУДЫН АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Эмийн сангийн нэр	Ажиллах өдөр	Цаг	Холбоо барих утас, хаяг
1	"Оюу" эмийн сан	2 сарын 05, 06, 07, 08, 09, 10нд	10:00-16:00	2-р баг Энхийнхүслэн ӨЭМТ-н дэргэд Утас: 89858988
		2 сарын 08, 09, 10нд	10:00-23:00	
2	"Хулан" эмийн сан	2 сарын 05, 06, 07, 08, 09, 10нд	10:00-18:00	4-р баг Сайхны 3-13 Утас: 88092497
3	"Төв эмийн сан" Эм хангамж ХХК	2 сарын 06, 07, 08нд	10:00-14:00	БОЭТ-н дэргэд Утас: 89707357, 88533621
4	"Энхмэнд" эмийн сан	2 сарын 07, 08нд	10:00-18:00	Өнө-Оших ӨЭМТ-н дэргэд ДС-ны 3-21 Утас: 89288855
5	"Мөнхийн рашаан" эмийн сан	2 сарын 07, 08, 09, 10нд	10:00-24:00	Баруун сайхан Өлзийт дэлгүүрийн хойд талд Утас: 89510439
6	"Алтан үндэс" эмийн сан	2 сарын 06, 07, 08, 09, 10нд	10:00-18:00	Арслан хотхонд Утас: 88225585